

## АГУУЛГА

<b>НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .....</b>	<b>2</b>
1.1 Төслийн ерөнхий мэдээлэл .....	<b>Error! Bookmark not defined.</b>
1.2 Ордын нөөцийн тооцоо .....	3
1.3 Үйлдвэрлэлийн ерөнхий зохион байгуулалт.....	4
1.4. Технологийн хэсэг .....	6
1.5. Өрөмдлөгө тэсэлгээний ажил .....	10
1.6 Ангилан ялгах хэсэг.....	15
1.7 Цахилгаан хангамж.....	15
1.8 Ус хангамж .....	15
1.9 Уурхайн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй.....	15
<b>ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .....</b>	<b>17</b>
<b>ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ.....</b>	<b>19</b>
<b>ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....</b>	<b>ERROR! BOOKMARK NOT DEFINED.2</b>
4.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө .....	25
4.2 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	<b>Error! Bookmark not defined.</b>
4.3 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө .....	28
4.4 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө.....	28
4.5 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө .....	28
4.6 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө .....	29
4.7 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө .....	27
4.8 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	28
4.9 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө .....	29
4.10 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь .....	35
<b>БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ .</b>	<b>37</b>

## ОРШИЛ

### ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Дорноговь аймаг, Айраг сумын нутагт орших “Самартай-1” нэртэй MV-016968 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайг 9011294066 тоот гэрчилгээтэй “Хөх Жонш” ХХК-д Геологи, уул уурхай кадастрын хэлтэсийн даргын 2011 оны 12 дугаар сарын 20 ний өдрийн 1120 тоот шийдвэрээр олгосон байна.

“Хөх Жонш” ХХК нь “Самартай-1” нэртэй MV-016968 хайлуур жоншны ордыг ашиглан орон нутаг, улс орны нийгэм, эдийн засагт доривтой хувь нэмэр оруулсан компани болхоор зорин ажиллаж байна.

“Самартай-1” нэртэй MV-016968 хайлуур жоншны ордыг ашиглах төсөл хэрэгжснээр улс орон нутгийн төсөвт татвар төлбөр хэлбэрээр нийт 15,578.6 сая төгрөгний орлого оруулах ба орон нутагт ажлын байр бий болж, орон нутгийн хүн ам ажлын байртай болсноор орон нутгаас бүтээгдэхүүний худалдан авалт нэмэгдэх, үйлчилгээний салбарт өсөлт гарах замаар эерэг нөлөө үзүүлэх бөгөөд бүс нутгийн эдийн засгийн хөгжлийг тодорхой хэмжээгээр дэмжих өндөр ач холбогдолтой юм.

Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2021 оны 07 сарын 29 ны өдрийн хуралдааны Т/154 тоот тушаалыг үндэслэн:

*Төсөлд ашиглалтын үеийн хаягдал 18.7% буюу 53,255.9 тн, бохирдол 14.6% буюу 41,412.0 тн байхаар тооцож геологийн бодитой В, боломжтой С зэргийн нөөцийг үйлдвэрлэлийн магадалсан В нөөцөд шилжүүлэн тооцсоноор үйлдвэрийн нийт нөөц 271,227.2 тн хүдэр, 133,818.4 тн хайлуур жонш олборлохоор тооцжээ. Үйлдвэрлэлийн энэхүү нөөцийг олборлохын тулд 9,957.39 мян.м3 рөөс хуулалт хийхээр тооцож жилд 40.0 мян.тн хүдэр олборлох хүчин чадалтайгаар ажиллах юм.*

### ТӨСЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

#### Төслийн нэр, үйл ажиллагааны чиглэл

“Самартай-1” нэртэй MV-016968 хайлуур жоншны ордыг ашиглах

#### Ашиглах технологи

Ордын хүдрийн биет нь гадаргууд шууд гарштай бөгөөд хайгуулын ажлын үед малтсан сувгууд 1-2 м зузаантай байна. Тухайн хүдрийн биет нь нарийн судал хэлбэрийн босоо уналтай тул ордыг далд аргаар ашиглах нь илүү зохимжтой.

Далд ашиглалтын системийн хувьд хүдрийн биетийн уналын өнцөг, зузаан, уурхайн хүчин чадал харьцангуй бага зэрэг хүчин зүйлсийг харгалзан хоршоолон олборлох ашиглалтын системийг сонгосон юм.

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА


### 1.1 Ордын байршил

“ХӨХ ЖОНШ” ХХК MV-016968 нэртэй энэхүү хайлууур жоншны ордын талбай нь Улаанбаатар хотоос зүүн урагш 360км Дорноговь аймгийн Айраг сумын төвөөс баруун урагш 50 км-т дэд бүтэц сайн хөгжсөн бүс нутагт оршино.

*Хүснэгт 1. Талбайн солбицол*

№	Уртраг			Өргөрөг		
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	109	20	53.75	45	21	46.58
2	109	20	30.75	45	21	46.58
3	109	20	30.75	45	22	6.59
4	109	20	53.75	45	22	6.59

Тусгай зөвшөөрөлийн талбай нь байр зүйн хувьд L-49-75 хавтгайд нийт 30.91 га талбайг хамарна.



*Зураг 1. Ордын байршилын зураг*

### **1.2. Физик газарзүйн нөхцөл, ландшафт**

Айраг сум нь Дорноговь аймгийн хойд хэсэгт нийт 7,442.6 км<sup>2</sup> газар нутгийг эзлэн сумын төв нь Цагаандөрвөлж хэмээх газар ХӨ 45<sup>0</sup>47', ЗУ 109<sup>0</sup>19'-д байрлана. Нутгийн төв цэг нь Улаан нуур ХӨ 45<sup>0</sup>37', ЗУ 109<sup>0</sup>16' бол хамгийн өмнө захын цэг нь ХӨ 45<sup>0</sup>2', ЗУ 108<sup>0</sup>11', хойд захын цэг нь ХӨ 46<sup>0</sup>11', ЗУ 109<sup>0</sup>12', баруун цахын цэг ХӨ 45<sup>0</sup> 10', ЗУ 108<sup>0</sup>8', зүүн захын цэг ХӨ 45<sup>0</sup>7', ЗУ 110<sup>0</sup>1' байна.

Улаанбаатар хотоос зүүн урагш 350 км, Дорноговь аймгийн төвөөс баруун хойш 130 км, далайн төвшнөөс дээш дунджаар 1000 м оршдог. Сумын хил хязгаарын хувьд хойд талаараа Дорноговь аймгийн Даланжаргалан, баруун болон баруун урд талаараа Иххэт, Алтанширээ сумтай, өмнө болно зүүн талаараа Сайхандулаан, Дундговь аймгийн Өндөршил сумуудтай хиллэдэг.

Айраг сум нь геоморфологийн хэв шинжийн хувьд Төв Азийн геоморфологийн их муж, Даланзадгад-Сайншанд, Баяндэлгэрийн дэд мужид хамаарагдана. Ерөнхийдөө нутгийн төв болон зүүн хэсгээр дунд ба шинэ төрмөлийн эриний сул барьцалдсан чулуулаг дээрх гүвээт, тэгш давхаргат тал, ширгэдэг нуурын ёроолын ба хужир марзат хэв шинжтэй. Харин Сайн-Ус багийн зүүн хойд хэсгээр татмын нам дэнжийн хурдаст талтай. Нард багийн нутгаар алаг цоог тархсан цав толгод ширгэдэг нуурын ёроолын ба нуур пролювийн хосолсон хэв шинжтэй.

Төслийн талбай район далайн түвшнээс дээш 1116-1140 метрийн үнэмлэхүй өндөрт байрласан нам уулс бүхий ухаа толгод, хөндий тэгш талыг хамарч тогтворжсон геоморфологийн тогтоцтой, газрын гадаргын налуу буюу хэвгий 0.7<sup>0</sup>-7.7<sup>0</sup> (градуст) байна.

### **1.3. Уур амьсгал**

Нарны нийлмэл цацраг

Айраг суманд хамгийн ойр орших нарны цацрагийн цаг уурын станц Сайншанд суманд байрладаг. Нарын нийлбэр цацрагийн дундаж 1500 квт.цаг/м<sup>2</sup> буюу нэг жилд нар гийгүүлэх хугацаа 3100 цаг байна.

Хүснэгт 1. Нарын нийлбэр цацраг

	Хавар	Зун	Намар	Өвөл
Өдрийн урт /цаг/	9-10	9-10	7-9	7 ба түүнээс их
Бүрхэг өдрийн тоо	5-7	5-7	1-3	1-3
Цэлмэг өдрийн тоо	7 ба түүнээс их	3 ба түүнээс их	13-15	15 ба түүнээс их
Нийт үүлшил /балл/	IV сарын байдлаар 4-6	VII сарын байдлаар 6-8	X сарын байдлаар 2-4	I сарын байдлаар 2

### **1.4 Агаарын температур**

Агаарын жилийн дундаж температур нь 30С бөгөөд 7 дугаар сарын агаарын дундаж температур +200С, 1 дүгээр сарын агаарын дундаж температур 180С байна. +300С ба түүнээс дээш температуртай өдрийн тоо дунджаар 30 байхад -300С ба түүнээс дээш температуртай өдрийн тоо дунджаар 20 байна. Агаарын температур хоногийн дундаж +100С ба түүнээс дээш байх өдрийн тоо 140 байгаа нь Монгол улсын нийт дунджаас харьцуулахад агаарын температур өндөр ажиглагдаж байна.

1985 он, 2014 оны агаарын дундаж температурыг сараар харьцуулж үзэхэд агаарын дундаж температур 1985 оны агаарын температураас 54% нэмэгдсэн үзүүлэлттэй байна (Зураг 6).

### 1.5 Хур тунадас

Хур тунадасны жилийн дундаж хэмжээ 150 мм үүнээс дулаан улирлын хур тунадасны дундаж хэмжээ 200 мм бөгөөд 5 мм ба түүнээс илүү хур тунадастай өдөр 10 байна (Зураг 7).

Харин хүйтэн улирлын хур тунадасны дундаж хэмжээ 15 мм, цас орсон өдөр 20 байна. Нутгийн хэмжээнд тогтвортой цасан бүрхүүл үүсэх хугацаа нь 12 сарын 1 - 10 хооронд, цасан бүрхүүл үүсэх дундаж хамгийн их зузаан нь 7,5 см байх бөгөөд энэ үеэр тогтвортой цасан бүрхүүлийн хугацаа олон жилийн дунджаар 75 өдөр үргэлжилнэ. Цасан бүрхүүл дунджаар 2 сарын 10 ханзарч эхэлнэ. Дунджаар аянгатай өдөр 15 байна.

1985 он, 2014 оны хур тунадасны дундаж температурыг сараар харьцуулж үзэхэд агаарын дундаж температур 1985 оны хур тунадаснаас 2.5 дахин буурсан үзүүлэлттэй байна.

Агаарын температурын өсөлт, хур тунадасны хомсдолтоос үүдэлтэй сүүлийн жилүүдэд ганд ихээр өртөж байгаа нь харагдаж байна.

Агаарын үнэмлэхүй хамгийн их температур +39.6 0C, агаарын үнэмлэхүй хамгийн бага температур -39.6 0C байна.

Хүснэгт 2. Агаарын сарын дундаж температур, 0C

Станц харуул	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	жил
Айраг	-19.5	-14.3	-6.3	5.1	13.7	19.5	21.8	19.9	13.2	3.9	-8.9	-17.4	2.6

Хүснэгт 3. Агаарын чийгшил хур тунадасны хэмжээ

Станцын нэр	Хоногийн хамгийн дулаан цагийн харьцангуй чийгшил		Хур тунадас					
	Халуун сар	Хүйтэн сар	Жил	Дулаан үе	Хоногийн хамгийн их	Он	Сар	Өдөр
Чойр	48	79	193.8	184.1	61.2	1967	VI	28

Агаарын даралт

Далайн төвшнөөс дээш 1500 м дэх агаарын жилийн дундаж даралт нь 846 гПа байна. Харин агаарын 1 дүгээр сарын дундаж даралт 848 гПа бол агаарын 7 дугаар сарын дундаж даралт 845 гПа ажээ.


Салхи

Жилд дунджаар 15 м/с ба түүнээс түүнээс хүчтэй салхитай өдөр 25, шороон шуургатай өдөр 20, цасан шуургатай өдөр 7, явган шуургатай өдөр 8 байна. Зураг төсөл, барилгын ажилд зориулсан салхины хурдын тооцоо үзүүлэлтээр газрын гадаргаас 10 м өндөрт салхины хурд 45 кг/м<sup>2</sup> байна.


Хүснэгт 4. Тодорхой саруудын салхигүй тохиолдлын тоо, хамгийн их хурд

Сар	Салхигүй тохиолдлын тоо	Хамгийн их хурд м/с
I	28	22
IV	20	19
VII	18	29

Сар	Салхигүй тохиолдлын тоо	Хамгийн их хурд м/с
X	26	22



Зураг 1. Салхины зүгийн давтагдал, дундаж хурд жилээр



Зураг 2. I, IV, VII, X сарын салхины зүгийн давтагдал, дундаж хурд

Хүснэгт 5. Салхины зүгийн давтагдал, дундаж хурд


зүг	Давтагдах /%/				Хурд /м/сек/			
X	42.5	20.2	23.4	21.4	3.9	6.8	4.3	4.2
3X	2.7	7.5	12.3	5.0	3.4	6.4	4.0	5.3
3	0.8	4.6	7.0	3.2	0.7	4.6	4.2	4.3
3Ө	7.7	10.8	14.4	14.7	1.3	4.4	4.0	3.7
Ө	2.6	7.9	17.7	12.1	1.2	4.2	4.1	3.8
БӨ	0.7	5.2	4.6	5.2	0.8	5.0	4.1	3.9
Б	2.2	10.3	7.0	8.4	1.2	5.3	4.5	4.6
БХ	40.5	53.7	23.5	29.9	1.9	6.2	4.8	5.1
Со	35.2	22.4	20.3	34.2				

Салхины өвлийн дундаж хурд 2.7 м/с, жилийн дундаж хурд 3.2 м/с


Харьцангуй чийг

13 цагийн байдлаар жилийн агаарын харьцангуй чийгийн дундаж 40%, 125 өдөр харьцангуй чийгшил 30% - аас бага байна. Агаарын харьцангуй чийгшил I сард 65%, IV сард 40%, VII сард 58%, X сард 48% (Зураг 21) агаарын харьцангуй чийг 30% ба түүнээс бага байх өдөр 10 – 20 байна.

Нийт нутгаар жилийн дундаж ууршилт 10 – 20 см бол ууршцын хэмжээ 80 см буюу түүнээс их байна.



Зураг 3. I, IV, VII, X сарын агаарын чийгшил



Зураг 4. I, IV, VII, X сарын агаарын дутмаг харьцангуй чийгшил

### 1.6 Гидрогеологийн судалгаа

Тухайн районд урсгал ус, гол горхи, булаг шанд байхгүй учир гүний усны талаарх судалгаа хийх шаардлагатай болсон. Шинээр өрөмдсөн 5 цооногт газрын доорх усны түвшин 28-36м-ийн гүнд илэрсэн бөгөөд түүнээс дээш сэвсгэр хурдасны доод хэсэгт чийгшилт зарим малталтанд мэдрэгдсэн.

Ордын геологийн нөхцлийг судлахын тулд бүх цооногуудад усны түвшин “хлопушка”-аар хэмжсэн ба хамгийн их устай байсан 6 ба 7-р цооногт шавхалт хийж туршсан болно.

Шавхалтыг БНХАУ-д үйлдвэрлэсэн жижиг насосоор гүйцэтгэсэн болно. Эдгээр цооногуудад тухайлбал 3-р цооногт 34м-ийн гүнд, 4-р цооногт 27м-т газрын доорх усны түвшин илэрсэн ба 1л/сек-ын хүчин чадалтай дээрх насосоор шавхалт хийхэд 3-р цооногт бминутын дараа, 4-р цооногт 11 минутын дараа ус нь бүрэн шавхагдаж дууссан ба цооногуудын усны статистик түвшин 3-р цооногт 8цаг 40 минутын дараа, 4-р цооногт бцаг 10мин дараа сэргэсэн нь тооцоогоор ус 0,01-0,05л/мин-ын ундаргатай болох нь тодорхойлогдсон ба бусад цооногт 24 цагийн дараа усны статистик түвшин хагас хувьд хүрэхгүй байлаа. Ийм учир ордыг ашиглах үеийн гидрогеологийн нөхцөл ямар нэг шавхалт хийх шаардлагагүйг илтгэж чадлаа. Харин ордын биетүүдээс 1-3км-т орших Элгэн худгийн хөндийд 1,5-3,0л/сек-ийн ундаргатай цооногууд илэрсэн нь үйлдвэрлэлийн усан хангамж эдгээрээс хангагдах боломжтой.

Харин талбайд гүний худаг байхгүй боловч талбайн гадна талд ордоос 1км хүрэхгүй зайд 5л/сек ундаргатай сайн чанарын устай худаг ажилладаг ба энэ худгаар ойр орчноо хангадаг. Үүнээс гадна Хар Айрагийн станцын төвд 1 моторт худаг байдаг нь тухайн районы ундны усыг хангаж байдаг, ундарга нь 6000л/3цаг буюу 2000л/цаг ундаргатай юм. Талбайгаас усны шинжилгээнд 5 дээж авсан боловч дээжийн битүүмжлэлийг сайн хийж чадаагүй, дээж нь авсан цагаас хойш 14 хоногийн дараа лабораторид очсон шалтгаанаар шинжилгээ хийхээс татгалзсан юм. Гэвч ус нь тунгалаг ямар нэг амтгүй, буцалган ширгээхэд саванд бага зэргийн цагаан өнгөр сууж байснаас дүгнэлт хийхэд гидрокарбонат найрлагатай байж болно гэж үзэж байна

Нуур: Улаан нуур, зүүн улаан нуур, дөрвөлжин нуур, гашуун тойром гэх мэт зун хур борооны усаар тэжээгддэг нууруудтай.


Худаг: Сумын төвд цэвэр усны эх үүсвэрийн гүний 4 худаг, 2 усан сан, 225 м3/хоног хүчин

чадалтай 1 насос станц, 20 м<sup>3</sup>/хоног хүчин чадалтай 1 ус зөөлрүүлэх, цэнгэгжүүлэх төхөөрөмж бөгөөд цэвэр усны 2.8 км урт шугам хоолойгоор ус түгээж байна.

Төвлөрсөн ус хангамжийн сүлжээ болох ТЗ –ын уурын зууханд 106 өрх, 8 аж ахуйн нэгж, ОН- ийн өмчит Чандмань Илч ХХК-ны уурын зууханд 130 өрх, 6 аж ахуйн нэгж холбогдож бусад айл өрх 1 ус түгээх байрнаас усаа авч байна.

Ариутгах татуурга: Сумын төвд ашиглалтаас гарсан 1 цэвэрлэх байгууламж, ашиглагдаж байгаа бохир усны ТЗ –д байгаа 124 худаг, 2.64 км урт шугам хоолой, Чандмань Илч ХХК –д 70 худаг, 3.5 км урт шугам хоолой байна. Төвлөрсөн ариутгах татуургын сүлжээнд нийт 236 өрх, 14 аж ахуйн нэгж холбогдоод байна.

Зураг 2. Сав газрын зураг



### 1.7. Амьтны аймаг

Дорноговь аймгийн Айраг сумын нутагт Их нарт байгалийн нөөц газар болон Цагаан дэлийн агуй дурсгалт газар тус тус байрладаг байна.

Их нарт байгалийн нөөц газар нь: Тал, хээр, говийн бүс хосолсон энэ нутагт ховор амьтан, ургамал ихтэй. Их Нартын чулуунд "Хульхан ам", "Шинэ усны ам", "Хөх усны ам", "Элсний ам", "Гурван хоногийн ам" зэрэг 1-3 км үргэлжилсэн булаг, модтой үзэсгэлэнт газрууд байхаас гадна жанжин Чойрын Их Нартын туурь зэрэг түүх, соёлын дурсгалт газрууд их байдаг. Их Нартын хадны Бургасны амыг 1988 онд аймгийн орон нутгийн хамгаалалтанд авч байсан байна. Байгалийн мужлалаар говийн бүсэд багтдаг боловч нутгийн баруун хойт хэсэг нь хээр талын бүсэд хамаарна. Амьтдаас аргаль, янгир, чоно, үнэг, хярс, мануул, шилүүс зэрэг туруутан, туулай, зурам, тарвага, сортон алагдахай байхаас гадна бүргэд, ногтруу, цэн тогоруу, хоёр төрлийн шонхор, ятуу, шар шувуу, ууль, хараацай, тас болон усны шувууд төрөл бүрээрээ байршин амьдардаг.

Цагаан дэлийн агуй дурсгалт газар нь: Байгалийн бүс, бүслүүрийн онцлог хэв шинж, унаган төрх, байгалийн өвөрмөц тогтоц, түүх, соёлын дурсгалыг хадгалах, ховордсон ургамал, амьтныг хамгаалах зорилгоор түүх, соёл, шинжлэх ухаан, танин мэдэхүй, экологийн хувьд онцгой ач холбогдол бүхий газар нутаг юм.



## 2. Нөөцийн тооцоо

### Нөөцийн тооцооны нэгдсэн хүснэгт

Самартайн ордын бодит /В зэрэглэлийн/ нөөцийг анх 209177,9 тн буюу 51,5%-ийн агуулагатай хүдрээр 107726,6 тн, боломжит /С зэрэглэлийн/ нөөцийг 18568,8 тн буюу 40,5%-ийн агуулагатай хүдрээр 7520 тн, Р зэргийн баялгийг 71203,6 тн буюу 49,6 %-ийн агуулгатай хүдрээр 3531,9 тн гэж тооцсон.

Гэвч ордыг ашиглаж эхлэхээс өмнө тус ордын I-I-р шугамаас IX-IX- шугамын хооронд 3,5 м дундаж гүнтэйгээр 1 ба 2-р биетийн хэсгээс авсан нөөцийг тооцож үзэхэд 12838,2 тн болж байгаа бөгөөд үлдэж буй нөөц нь В зэрэглэлээр 197416,2 тн буюу 51,5 %-н агуулагатай жоншоор 101669,3 тн, боломжит зэрэглэлээр нөөц 17492,3 тн буюу 40,5% ийн агуулагатай жоншоор 7084,3 тн болж багассан байна.

ЭБМЗ-ийн хуралдааны бүх гишүүдийн саналаар бүх нөөцийг С нөөцөд хамааруулж С-1 блокийн нөөцийг хүдрээр 174108,98 тн , 47,75 %ийн агуулагатай флоритоор 83137 тн, С-2 блокийн нөөцийг хүдрээр 6180,95 тн, 43,58 %ийн агуулагатай флоритоор 2693,65 тн-оор хүлээн авч баталсан байна.

/ЭБМЗ-ийн 2007 оны 10-р сарын 11-ний өдрийн 18-02 тоот хуралдааны дүгнэлт,  
АМХЭГ –ын даргын 2007 оны 10-р сарын өдрийн 374 тоот тушаал/

Боломжтой С-1 нөөц нь хуучин В нөөц, С-2 нөөц нь хуучин С нөөц нь тул нөөцийн тооцоог хуучин нөөцийн үзүүлэлтээр тооцон гаргасан.

Судлын 1-р биетийн урт нь 232м, 2 –р судлын урт нь 188 м сунасан тархалттай, судлын дундаж өргөн 20-30 м харилцан адилгүй. Хайгуулын III, V, VII, IX-р шугаманд 0,8-1,8м зузаантай, хайгуулын I, III-р шугаманд 1,2-1,8м зузаантай чулуулгийн үенцэртэй. Хүдрийн давхаргын судлын зузаан харилцан адилгүй зарим хэсэгтээ 16м хүртэл тохиолдоно.

Уулын ажил явуулах дундаж талбайг 240x120м буюу 28800м<sup>2</sup>, гүнийг +1000м-ийн түвшинд 40-50м-ээр тооцсон. Орд нь нийтдээ 1045-1050 м-ийн үнэмлэхүй өндөржилт тэгш бус гадаргуутай.

### Хүдрийн биетэд хэсэгшлээр нөөц тооцсон хүснэгт

#### Хүснэгт №2

Хэсэгчлийн дугаар	Хүдрийн биетийн жинхэнэ талай м 2	Дундаж зузаан /м/	Хүдрийн эзэлхүүн м <sup>3</sup>	Хүдрийн нөөц		Хууль бусаар олборлох тн	Үлдэж буй нөөц тн	Дундаж агуулга CaF	Жоншоор
				/ м <sup>3</sup> /	/тн/				
1-С-1	222,4	0,90	2,7	200,2	540,4	60,8	479 7	41,1	197,15
2-В-1	2239,6	3,00		6718,8	18140,6	810,0	17330,6	53,1	9202,56
3-В-1	2479,2	6,60		163,62	44178,8	17820	42396,6	57,6	24420,53
4-В-1	2425,9	8,60		20871,1	56352,0	2322,0	54030,0	59,8	32308,96
5-В-1	1987,1	6,70		13313,5	35946,3	1809,0	34137,3	51,9	17717,28
6-В-1	1500,0	3,90		5850,0	15795,0	789,8	15005,3	45,2	6782,37
1-С-2	182,29	0,70		127,6	344,5	28,4	316,2	44,6	141,02
2-В-2	1385,42	1,80		2493,8	6733,1	486,0	6247,1	44,8	2798,71
3-В-2	1499,69	3,60		5398,9	14577,0	972,0	13605,0	56,4	7673,20
4-В-2	1002,08	4,40		4409,2	11904,8	1188,0	10716,8	53,4	5722,74
5-В-2	993,75	3,60		3577,5	9659,3	972,0	8687,3	49,1	4265,44
6-В-2	512,08	1,0		512,1	1382,6	151,9	1230,8	43,7	537,84
1-С-2А	208,33	0,90		187,5	506,3	45,6	460,7	28,1	129,45
2-В-2А	831,25	2,30		1911,9	5162,1	621,0	4541,1	44,7	2029,85
3-В-2А	772,40	2,40		1853,8	5005,1	648,0	4557,1	48,9	2130,63
4-В-2А	562,50	1,00		562,5	1518,8	151,9	1366,9	46,3	632,86
<b>Дүн</b>				84350,6	227746,6	12838,2	214908,4	48	166691,6
<b>Бодит Нөөц В</b>				66931,4	180714,8	6605,8	170527,8	51,5	108903,8
<b>Бодит Нөөц С</b>				4597,5	12413,3	6232,3	44380,6	40,5	7658,4

### 3. БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Самартай-1 хайлуур шоншны ордыг олборлох үед үүсэх нөлөөллийг тогтоохдоо төслийн байгаль орчин, нийгмийн бүрэлдэхүүн хэсгүүдэд үзүүлж болох болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг нарийвчлан тогтоох зорилгоор өмнөх бүлгүүдэд авч үзсэн төслийн техник, технологи, завсрын бүтээгдэхүүн, хог хаягдал, байгаль орчны суурь үнэлгээ зэрэгт тулгуурлан “Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай хууль”, БОАЖЯ-наас гаргасан нарийвчилсан үнэлгээ хийх аргачлал, НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссоос гаргасан “Матриц”-ын аргыг ашиглан байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд нөлөөлөх нөлөөллийг тодорхойлсон.

#### Хүснэгт.9 Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

Нөлөөлөлд өртөх бүрэлдэхүүн хэсгүүд	Төслөөс үзүүлж болзошгүй сөрөг нөлөө
Газрын хэвлий	➤ Нийт 1.8 га талбай газарт ил уурхайн аргаар олборлолт явуулж газрын хэвлийн чулуулгийн тогтоц, бүтцэд сөрөг нөлөө үзүүлнэ.
Эдэлбэр газар	➤ Нийт 2.5 га талбай уурхайн барилга байгууламжид өртөснөөр бэлчээр хязгаарлагдах, газрын гадаргад эвдрэл үүсэх, газар эзэмших боломжийг хязгаарлах, мал амьтанд аюултай уурхайн малталт үүсэх зэрэг сөрөг нөлөөтэй.
Агаар	<ul style="list-style-type: none"> <li>➤ Өнгөн хөрс хуулалт, хөрсний овоолго, уурхайн тээвэрлэлт зэрэг технологи ажиллагаанаас тоосжилт үүснэ.</li> <li>➤ Машин техникийн түлшний шаталтаас агаар бохирдуулагч хий ялгарна.</li> <li>➤ Ажилчдын кемпийн ахуйн хог хаягдал болон засварын газраас шатах тослох материалын үнэр хязгаарлагдмал орчинд тархах</li> </ul>
Ус	<ul style="list-style-type: none"> <li>➤ Гүний усны нөөц горим алдагдах, чанар өөрчлөгдөх</li> <li>➤ Ахуйн бохир усыг зөв зохицуулаагүйгээс үүдэн хөрс, усны бохирдолт үүсэх</li> <li>➤ Технологи эргэлтийн усны далан хаалт сэтэрснээс үүдэн хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт сөргөөр нөлөөлөх</li> </ul>
Хөрс	<ul style="list-style-type: none"> <li>➤ Уурхайн үйл ажиллагаа явуулах 1.8 га талбайн хөрсөн бүрхэвч хуулагдаж үржил шим, механик бүрэлдэхүүн өөрчлөгдөнө.</li> <li>➤ Уурхайгаас баяжуулах үйлдвэр хүртэлх дотоод замын хөрс хуулагдаж үржил шим, механик бүрэлдэхүүн өөрчлөгдөнө.</li> <li>➤ Ахуйн хог хаягдал болон машин техникийн засварын үйл ажиллагаанаас хөрсний бохирдол хязгаарлагдмал орчинд үүснэ.</li> <li>➤ Ажилчдын кемп, баяжуулах үйлдвэр, хөрсний овоолго зэрэгт өртсөн талбайн хөрс элэгдэл эвдрэлд орно.</li> </ul>
Ургамал	<ul style="list-style-type: none"> <li>➤ Уурхайн олборлолт хийх талбай болон баяжуулах үйлдвэрийн барилга байгууламж, шугам сүлжээний ажлаас үүдэн бэлчээрийн ургамлын биомасс устаж талхлагдана.</li> <li>➤ Хөрс хуулалт (овоолго) дотоод, гадаад тээвэрлэлт, барилга байгууламжийн угсралт зэргээс үүдэн ургамал ургалтанд сөрөг нөлөө үзүүлнэ.</li> </ul>
Амьтны аймаг	<ul style="list-style-type: none"> <li>➤ Машин техник хэрэгслийн дуу чимээ, шатах тослох материалын үнэр зэргээс зэрлэг туурайтан амьтны амьдрах орчин өөрчлөгдөх (дайжих), устах зэрэг</li> <li>➤ Уурхайн талбайд хөрс хуулах явцад шавьж болон нүхэнд амьдардаг амьтад устах мөн амьтны аймгийн байршил, зүйлийн бүрдэл, зан төлөвт өөрчлөлт орох магадлалтай.</li> </ul>
Түүх соёлын өв	➤ Тусгай зөвшөөрлийн талбайд түүх соёлын өвийг илрүүлэх хайгуул судалгаа явуулж авран хамгаалах арга хэмжээ авсан.
ТХГН	➤ Төслийн талбайтай давхцалтай болон хил залгаа ТХГН байхгүй байна.

### 3.1 Байршилтай холбоотой төслийн нөлөөллийн цар хүрээ

Байршилтай холбоотой төслийн нөлөөллийг тодорхойлохдоо хуулиар хамгаалсан газар нутагтай давхцалтай эсэх, төсөл хэрэгжих орон нутгийн эмзэг байдал зэргийг шалгуур үзүүлэлт болгон үнэлсэн. Төсөл хэрэгжих талбай нь улсын тусгай хамгаалалттай газар нутагтай давхцалгүй. Мөн гол мөрний урсац бүрэлдэх эх, усан сан бүхий газрын хамгаалалтын бүсийн хилийн зааг, ойн сан бүхий газрын хилийн заагтай тус тус давхцалгүй.

Уур амьсгалын хувьд талбай нь Төв Азийн хуурай эрс тэс уур амьсгалтай, зуны улиралд гандуу дулаан, өвөл нь хүйтэн бүсийн нутагт хамаарагдана. Хавар, намрын улиралд салхи шуургатай өдрүүд олон байдаг. Салхины зонхилох чиглэл баруун, баруун хойноос зүүн, зүүн өмнө зүгт дунджаар 4.6 м/с ба хамгийн их хурд нь 30 м/с байна. Агаарын дундаж даралт 818 – 850 к.Па. Хур тунадас ерөнхийдөө ховорхон ордог ба жилд 82.4мм. Хүйтний улиралд 5- 10мм, тунадастай өдөр 10-20, зуны улиралд 5мм-ээс их, хуртай өдөр 10 орчим байх ба хамгийн их хур тунадас 50-100 мм хүрдэг. 12-р сарын 10 гэхэд тогтвортой цасан бүрхүүл тогтож, эрт ханзарч (2-р сарын 10-наас 3-р сарын 1) эхэлнэ.

Төслийн ойр орчим суурин газар байхгүй бөгөөд газар ашиглалтын ямар нэг зөрчил үүсэхгүй, богино хугацааны, энгийн технологитой уг төсөл нь байршлаас үүдэн гарах нөлөөлөл бага, өөрөө зохицуулагдах боломжтой байна.

#### Хүснэгт.10 Байршилтай холбоотой төслийн нөлөөллийн цар хүрээ

Сөрөг нөлөөлөл	Нөлөөллийн хэлбэр			Нөлөөллийн үнэлгээ			
	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	нөлөөгүй	бага	Дунд	Их
<b>Хуулиар хамгаалагдсан газар нутагт үзүүлэх нөлөө</b>							
Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усан сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газрын хамгаалалтын бүстэй давхцалтай эсэх			x	x			
ТХГН төслийн талбайтай давхцалтай эсэх			x	x			
<b>Төсөл хэрэгжих нутгийн эмзэг байдалд үзүүлэх нөлөө</b>							
Жилд орох хур тунадаснаас үүсэх нөлөө			x		x		
Зуны улирлын хэт халалт, өвлийн улирлын хэт хүйтрэлээс үүсэх нөлөө			x		x		
Орон нутгийн салхи тогтворгүйгээс үүсэх нөлөө			x		x		
<b>Нөлөөллийн хуримтлагдах байдал</b>							
Төслийн хугацаа	x				x		
Төслийн талбайтай хил залгаа уурхай талбай байгаа эсэх (хуримтлагдах нөлөөлөл)	x				x		
Дүгнэлт: Төслийн байршилтай холбоотой нөлөөллийг 7 шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд өөрөө зохицуулагдах 5, шууд нөлөө үзүүлэх 2, нөлөөллийн эрчмээр нөлөөгүй 2, бага нөлөөтэй 5 үзүүлэлт байна.							

### 3.2 Газрын гадарга болон хэвлийд үзүүлэх сөрөг нөлөө

Олборлолтын үйл ажиллагаанаас газрын гадарга болон хэвлийд үзүүлэх гол сөрөг нөлөөлөл нь ил уурхайн талбай (ухаш), далан, овоолго үүсгэх зэргээр газрын гадаргын хэлбэр дүрс, байгалийн тогтоцыг өөрчлөх ба нийтдээ 8.67 га талбай эвдрэлд орно. Үүнээс Эвдрэлд өртөх ил уурхайн талбай (1.8), хоосон чулуулгийн овоолго, баяжуулалтын хаягдал, шимт хөрсний овоолго (4.37 га), уурхайн технологийн зам, кэмп зэрэг талбайн -/2.5/ га хөрс элэгдэж нийт 8.67 га талбай эвдрэлд өртөхөөр байна.

Хүснэгт 11. Газрын гадарга болон хэвлийд үүсэх сөрөг нөлөөлөл

№	Сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийн эрчмийн зэрэг			
		Нөлөөгүй	Бага	Дунд	Их
1	Уурхайн тоног төхөөрөмж, дэд бүтцийн байгууламжийг барих явцад газрын гадарга эвдрэлд орж унаган төрхөө алдах			x	
2	Гадаад болон дотоод овоолго үүсгэх тухайн талбайн газрын гадаргын үндсэн хэв шинж дарагдаж өөрчлөгдөх			x	
3	Уурхайн олборлолтын үед газрын хэвлийн тогтоц, чулуулгийн сийрэгжилт, дотоод эвдрэл үүсэх, газрын гадаргад хоосон орон зай бий болох			x	
4	Тээвэрлэлтийн үед олон салаа зам үүссэнтэй холбоотойгоор газрын гадарга эвдрэлд орох, үндсэн хэв шинж өөрчлөгдөх		x		

Дүгнэлт: Газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг 4 шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд бага нөлөөтэй 25 хувь, дунд зэрэг нөлөөтэй 50 хувь, их нөлөөтэй 25 хувь байна. Их нөлөөллийг төсөл хэрэгжиж дуусахад техникийн болон биологийн бүрэн нөхөн сэргээлт хийж байгалийн унаган төрхөнд оруулна.

**3.3 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөө**

Ашиглалтын үед агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл нь хөрс хуулах, овоолго үүсгэх, машин механизмын хөдөлгөөнөөс тоос босох, хорт хий ялгарах зэрэг орно. Тухайлбал:

- Хөрс хуулах, элс олборлох үед тоос, шороо ихээр үүсэх
- Уурхайн малталтууд болон овоолгын дээд талбайгаас салхинд хийсэх тоос, шороо
- Уурхайд ажиллах машин техникүүдийн шингэн түлшний шаталтаас ялгарах утаа, хөө тортог, хорт хийнүүд
- Хөрс хуулах, түрэх, тээвэрлэх, элс угаах зэрэг бүхий л ажиллагаа тасралтгүй явагдах тул бульдозер, экскаватор, автомашин, бусад төхөөрөмжийн дуу чимээ, утаа тортог, тоос шороо дэгдэх зэргээр агаарын орчныг бохирдуулж, хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд сөргөөр нөлөөлж болзошгүй байна.

Хүснэгт.12 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл

№	Сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийн эрчмийн зэрэг			
		Нөлөөгүй	Бага	Дунд	Их
1	Шимт хөрс хуулалт, элс олборлолт явагдаж эхлэхэд ухаж ачих, тээвэрлэх, овоолго үүсгэх зэрэг үйл ажиллагаанаас тоосжилт үүсч агаарын чанарт сөргөөр нөлөөлөх			x	
2	Хүнд даацын машин механикмын хөдөлгөөнөөр хөрсөн бүрхэвч элэгдэн, сул шороо үүссэнээр тоосжилт ихсэж агаарын чанарт нөлөөлөх			x	
3	Тээврийн хэрэгслийн түлшний шаталт болон засвар үйлчилгээний үед хийн бохирдол үүсэх		x		
4	Үйл ажиллагааны үед үүсэх физик бохирдол буюу дуу чимээ		x		
5	Салхи болон цаг агаарын хүчин зүйлсээс шалтгаалан агаарын бохирдол оронзайд зөөгдөх		x		

Дүгнэлт: Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг 5 шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд 60 хувь бага 40 хувь дунд нөлөө үзүүлэхээр байна. Төслийн үйл ажиллагаагаар агаарын чанарт үзүүлэх хамгийн их сөрөг нөлөөлөл нь элс олборлох, ачиж тээвэрлэх явцад бий болох ба үүнийг төслийн үйл ажиллагааны явцад зам талбайд үүсэх тоосжилтыг дарах усалгааны ажлыг тогтмол хийх замаар багасгах бүрэн боломжтой.

### 3.4 Гүний усанд үзүүлэх сөрөг нөлөө

Уурхайн ойр орчимд гадаргын уст цэг байхгүй. Тиймээс гадаргын усанд үзүүлэх сөрөг нөлөөлөл байхгүй. Самартай-1 ордыг олборлох явцад гүний усны шүүрэл бага зэрэг илрэх болохыг тооцсон. Олборлолтын үйл ажиллагааны явцад аадар бороо орж их хэмжээгээр үер буух тохиолдолд түүгээр бохирдол зөөгдөн гадаргын болон гүний усыг бохирдуулах нөхцөл үүсч болзошгүй.

Дөрөвдөгчийн сэвсгэр хурдсаар хучигдсан ан цавжилт, хагаралд хүчтэй өртсөн, кварцийн судлаар хэрчигдсэн Силур-Девоны Номгоны формацийн занар болон андезит байна. Газрын доорх усны тэжээгдлийн муж дахь түвшний зөрүүнээс шалтгаалан уст давхарга нь даралттай нөхцөлд оршино. Уурхайн олборлолтын явцад хүдрийн 2,3-р биетийн ил уурхайгаас усны ханын шүүрэл үүсэх бөгөөд уурхайн ёроолд үүссэн усыг насосоор соруулж уурхайн гадаргуу дээр хиймэл нуур үүсгэн орон нутгийн малчдын малын усалгааны газар бий болгоно.

Хүснэгт.14 Гүний усанд үзүүлэх сөрөг нөлөө

№	Сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийн эрчмийн зэрэг			
		Нөлөөгүй	Бага	Дунд	Их
1	Уурхайн усны хэрэглээгээр гүний уст давхаргын нөөц горимд өөрчлөлт орох			x	
2	Шатах, тослох материалын асгаралт болон уурхайн үйл ажиллагаагаар бохирдсон ус хөрсөнд ил хаягдан нэвчиж улмаар гүний уст давхаргын чанарт өөрчлөлт орох		x		
3	Уурхайн барилга байгууламж, ухаш үүсгэх, далан болон усан сан байгуулах үйл ажиллагаагаар газрийн гадарга өөрчлөгдөж гүний уст давхаргын тэжээгдлийн системд өөрчлөлт орох, тэжээгдэл багасах		x		
Дүгнэлт: Гүний усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг 3 гол шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд 66 хувь нь бага, 33 хувь нь дунд зэрэг сөрөг нөлөө үзүүлэхээр байна.					

### 3.5 Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөө

Уурхайн талбай нь Айраг сумын төвөөс баруун урд зүгт Самартай-1 нэртэй ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд байрлалтай. Лицензийн талбай нь нам, дундаж өндөр толгод гадаргууг дамнан байрласан. Үнэмлэхүй өндөр 1400-1600 метрийн үнэмлэхүй өндөр бүхий гадаргууд байрласан. Нөлөөллийн бүсийн талбай, түүний орчимд Монгол орны хөрсний ангиллаар Заримдаг цөлийн бор хөрс болон Цөлийн бор саарал хөрсний хэвшинжид хамаарагдах 6-7 төрлийн хөрс тархсан.

Хүснэгт.15 Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөө

№	Сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийн эрчмийн зэрэг			
		Нөлөөгүй	Бага	Дунд	Их
1	Уурхайн тоног төхөөрөмжийг суурилуулах, дэд бүтцийн барилга байгууламжийг байгуулах үед тухайн орчны өнгөн хөрс элэгдэх, үржил шимт чанараа алдах				x
2	Үржил шимт хөрс хуулалт, элс олборлолтын үйл ажиллагаагаар тухайн орчны хөрсөн бүрхэвч гадаргаас зайлуулагдах				x
3	Уурхайн гадаад болон дотоод овоолго үүсгэх талбайн хөрс дарагдаж үндсэн хэв шинж өөрчлөгдөх			x	
4	Хүдэр тээвэрлэлтийн явцад хүнд даацын машин механизмын нөлөөгөөр хөрсөн бүрхэвч элэгдэж эвдрэлд орох, сул шороо ихээр үүсэх			x	

5	Ахуйн хог хаягдал, машин техникийн засварын үйл ажиллагаагаар хязгаарлагдмал орчинд хөрс бохирдох		x		
Дүгнэлт: Хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөллийг 5 шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд 20 хувь нь бага, 40 хувь нь дунд, 40 хувь нь их нөлөө үзүүлэхээр байна. Уурхайн олборлолтонд өртөх талбайг төслийн хаалтын үйл ажиллагаагаар бүрэн нөхөн сэргээж байгалийн унаган төрхөнд оруулна.					

### 3.6 Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөө

Уурхайн талбайн орчмоор нам уулс, ухаа толгод, уулын бэл хормойн, хотос хоолой, сайр садаргын болон баянбүрдийн ургамалжлын хэвшинж зонхилно. Эдгээрээс талбайн орчмоор нам уулсаас хотгор хоолой руу хойшоо чиглэн бууж ирсэн хуурай сайрын садаргын болон баянбүрдийн ургамалжил зонхилно. Эдгээр хотгор хоолойнууд нь мезозойн хурдасаар элбэг, алаг цав толгод, эрэг мөргөцөг ихтэй. Хөрс нь хавийн уулсаас эртнээс усаар туугдан ирж үйрмэгжээд хожим хүртэл говийн наранд түлэгдэн харласан чулуун хуяган бүрхүүлтэй болсон байх тул чулуут цөл зонхилно.

#### Хүснэгт.16 Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөө

№	Сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийн эрчмийн зэрэг		
		Бага	Дунд	Их
1	Уурхайн баяжуулах тоног төхөөрөмж болон бусад барилга байгууламжийг байгуулах үйл ажиллагаанаас газрын гадарга эвдрэлд орох ба тухайн талбайн ургамлан нөмрөг зайлуулагдах, зарим нь устах			x
2	Хөрс хуулалтын явцад үүсэх тоос, машин техникээс ялгарах утаа, олон төрлийн хүнд элементүүд тухайн орчны 15-50 м зай доторх ургамлан нөмрөгийн фотосинтезийн идэвхитэй туяа шингээлтийг бууруулах	x		
3	Шимт хөрс, элсний овоолго байгуулах талбайн ургамлан нөмрөг дарагдаж, үндсэн хэв шинж, шинж чанараа алдах		x	
4	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний нөлөөгөөр ургамлан нөмрөг талхлагдах, доройтох	x		
5	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн болон байнгын газар шорооны ажилтай холбоотойгоор үүсэх тоосжилт ургамлан нөмрөгт дам нөлөөлөл үзүүлэх	x		
6	Шатахуун хадгалах, түгээх явцад асгаралт үүссэнээр ургамлан нөмрөг бохирдох		x	
7	Машин техникийн засвар үйлчилгээний үед шатах тослох материалын асгаралт үүсч ургамлан нөмрөгийг бохирдуулах		x	
Дүгнэлт: Самартай-1 орд ашиглах төслөөс ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөллийг нийт 7 үйл ажиллагаанаас үүсэх нөлөөллөөр тооцсон. Тэдгээрийн 3 буюу 43% нь “бага”, 3 буюу 43% нь “дунд”, 1 буюу 14% нь “их” гэсэн нөлөөллийн үнэлгээний зэрэгт хамрагдаж байна. Үүнээс үзэхэд төслөөс ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл нь дунд зэрэг байна.				

### 3.7 Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөө

Тус нутагт 10 баг, 52 овгийн 158 зүйл шавж, 7 зүйл мөлхөгч, 12 багийн 53 зүйл шувуу, 7 багийн 31 зүйл хөхтөн амьтан тэмдэглэв.

#### Хүснэгт.17 Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөлөл

№	Сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийн эрчмийн зэрэг			
		Нөлөөгүй	Бага	Дунд	Их
1	Дэд бүтцийн барилга байгууламж угсралтын үед амьдрах орчны унаган төрх, хэв шинж алдагдах, амьтад амьдрах орчноосоо дайжих		x		
2	Хөрс хуулалт явагдаж хөрсний овоолго үүсгэх явцад амьтдын амьдрах орчин алдагдах, дайжих, шилжих хөдөлгөөн бий болох, хөрсөнд үүрлэн амьдрагч амьд биетүүд устах			x	
3	Хүнд даацын машин механизмын хөдөлгөөний улмаас амьтад амьдрах орчноосоо дайжих, машин механизмд дайруулах		x		

4	Шатахуун хадгалах, түгээх явцад гэнэтийн осол аваарын улмаас шатах, тослох материал асгарч амьдрах орчныг бохирдуулж, доройтуулах		x		
5	Засвар үйлчилгээний явцад техникийн дуу чимээгээр амьтад үргэж дайжих, тослох материал зэргийн асгаралтаар амьдрах орчин бохирдох			x	
Дүгнэлт: Амьтны аймагт үзүүлэх нөлөөллийн 5 шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд 60 хувь нь бага, 40 хувь нь дунд нөлөөлөлтэй байна. Иймээс төслийн үйл ажиллагаагаар амьтны аймагт дунд зэргийн сөрөг нөлөө үзүүлэхээр байна.					

### 3.8 Түүх соёлын өвд үзүүлэх сөрөг нөлөө

Одоогийн байдлаар Самартай-1 уурхайн ашиглах талбайгаас ямар нэгэн археологийн болон палентлогийн дурсгал илэрч олдоогүй. Гэвч газрын хөрсөнд булагдсан дурсгал олдвор байхыг үгүйсгэхгүй тул ашигт малтмалын хайгуулын өрөмдлөг, уул уурхайн бусад ажлын явцад анхаарал болгоомжтой ажиллаж, ямар нэгэн олдвор дурсгал илэрсэн тохиолдолд нэн даруй мэргэжлийн байгууллагад мэдэгдэх болно.

### 3.9 Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний нэгтгэл

Ордыг олборлох үйл ажиллагаанаас үүсэх сөрөг нөлөөллийг нийт 31 шалгуур үзүүлэлтээр тодорхойлоход 2 нөлөөгүй, 13 бага нөлөөтэй, 12 дунд нөлөөтэй, 4 их нөлөөтэй байна. Сөрөг нөлөөллийг хувиар илэрхийлбэл 6.4 нөлөөгүй, 42 бага, 38.7 дунд, 12.9 их нөлөөтэй байна. Хөрсөн бүрхэвч, амьтны аймаг, газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг 5 шалгуур үзүүлэлтээр, ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөллийг 7 шалгуур үзүүлэлтээр, газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг 4 шалгуур үзүүлэлтээр, гүний усанд үзүүлэх нөлөөллийг 3 шалгуур үзүүлэлтээр тус тус тодорхойлсон.

Хүснэгт.18 Эрчмийн аргаар үнэлсэн сөрөг нөлөөллийн үнэлгээний нэгтгэл

№	Байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг	Сөрөг нөлөөлөл				Үнэлгээ	
		Нөлөөгүй	бага	Дунд	Их	Тоо	хувь
1	Газрын гадарга болон хэвлий		1	2	1	4	12.9
2	Агаарын чанар		3	2		5	16.2
3	Гүний ус		2	1		3	9.6
4	Хөрсөн бүрхэвч		1	2	2	5	16.2
5	Ургамлан нөмрөг		3	3	1	7	22.5
6	Амьтны аймаг		3	2		5	16.2
7	Түүх соёлын өв	1				1	3.2
8	Тусгай хамгаалалттай газар нутаг	1				1	3.2
Нөлөөллийн эрчмийн нийт үнэлгээ		2	13	12	4	31	100.0
		6.4	42	38.7	12.9		



## 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

### 4.1 Эрх зүйн үндэслэл ба түүний гол шаардлага

2012 онд шинэчлэн батлагдсан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд зааснаар “Самартай-1” хайлуур жоншны ордыг ашиглах төсөл нь тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэг нь төсөл хэрэгжүүлэгч “Хөх жонш” ХХК-д тавигдаж байна.

Иймд шинэчлэн баталсан хуулийн дагуу “Самартай-1” хайлуур жоншны ордыг ашиглах төслийн үйл ажиллагааны явцад баримтлах байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулав. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах болон нөхөн сэргээлт хийх журам, аргачлалыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нөхөн сэргээлтийн стандартыг холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллага тус тус батлан мөрдүүлнэ.

Шинэчлэн батлагдсан хуульд Байгаль орчин, Аялал жуулчлалын яам /БОАЖЯ/ тухайн төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлан, төсөл хэрэгжүүлэх зөвшөөрлийг олгох, жил бүрийн хэрэгжилтийн тайланг хянаж дараа жилийн төлөвлөгөөг батлах замаар уг төлөвлөгөөний хэрэгжилтийн хяналт нэлээд тодорхой болох ач холбогдолтой юм.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр гэсэн хоёр үндсэн хэсгээс бүрдэх бөгөөд байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгахаар хуульчлагдсаныг баримтлан БОМТ, ОХШХ-ийг боловсруулав.

Нөгөө талаас “Самартай-1” хайлуур жоншны ордыг ашиглах төслийг хэрэгжүүлэгч “Хөх жонш” ХХК нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын буюу одоогийнхоор БОАЖЯ-ны нөхөн сэргээлтийн тусгай дансанд ашиглалтын үйл ажиллагаа дуусах хүртэл жил бүр тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг төвлөрүүлнэ. Хэрвээ “Хөх жонш” ХХК нь байгаль хамгаалах талаар хуулиар хүлээсэн үүргээ хангалттай биелүүлж, жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг биелүүлсэн бол Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 14.1.3-т заасан хаалтын менежментийн төлөвлөгөөний биелэлтийн явцыг үндэслэн мөн хуулийн 9.10-т зааснаар хуримтлагдсан хөрөнгийг тодорхой хуваарийн дагуу буцаан олгохоор зохицуулагдсан.

Гэхдээ БОАЖЯ байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт, нөхөн сэргээлтийн ажлын гүйцэтгэл болон тус хуулийн 9.12-т зааснаар хянуулсан хяналтын дүнд хөндлөнгийн хяналт хийлгэж, дүгнэлт гаргуулах бөгөөд уг дүгнэлт төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг үндэслэн баталгааны мөнгийг буцаан олгох эсэх асуудлыг энэ тухай хуулийн 9.15-д заасан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журмын дагуу шийдвэрлэх юм.

“Самартай-1” хайлуур жоншны ордыг ашиглах төслийг хэрэгжүүлэгч “Хөх жонш” ХХК нь тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 12 дугаар сард багтаан БОАЖЯ-нд хүргүүлж дараа оны төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлын хэмжээг батлуулах үүрэгтэй.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд тухайн орон нутгийн байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүх шатны засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага болон байгаль орчны төрийн бус байгууллага хяналт тавих эрхтэй бөгөөд тэдгээрт холбогдох мэдээллээ ил тод болгох, тодорхой хуваарийн дагуу хяналт хийх боломжийг бүрдүүлэх шаардлага бас тавигдсан.

#### **4.2 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилтууд**

Төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилтуудыг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнгүүд болон Байгаль орчин, Аялал жуулчлалын яамны уг төсөлд хийсэн ерөнхий үнэлгээний дүгнэлтэд заасан шаардлагууд дээр үндэслэн тодорхойлсон. Мөн 2012 оны 5 дугаар сард УИХ-аар хэлэлцэн баталсан байгаль орчны багц хуулиуд Тухайлбал, Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Усны тухай, Ус бохирдуулсны төлбөрийн тухай, Хөрс хамгаалах, Цөлжилтөөс сэргийлэх тухай, Ургамал хамгааллын тухай, Амьтны тухай, Агаарын тухай, Хог хаягдлын тухай, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай зэрэг хуулиуд түүнтэй холбогдох бусад хуулиудад орсон өөрчлөлтүүд ялангуяа аж ахуйн нэгжийн байгаль хамгаалах талаар хүлээх үүргүүдийг тусгасан болно.

Хайлуур жоншны ордыг далд аргаар ашиглах төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд<sup>1</sup> 2022-2026 онд урьдчилсан байдлаар **202557.8** мян.төгрөг /үүнээс гадна хаалтын зардалд 408600.0 **мян.төг/** зарцуулахаар тусгасан. “Хөх жонш” ХХК нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 5 жил тутамд нэмэлт тодотгол хийлгэх, төслийн цар хүрээ энэхүү үнэлгээнд авч үзсэн техник технологи, хүчин чадал өөрчлөгдсөн тухай бүр зохих журмын дагуу Байгаль орчин, Аялал жуулчлалын яаманд хандаж нэмэлт тодотгол хийлгэж ажиллах шаардлагатай.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласнаар уурхайн олборлолтын үед гарч болзошгүй сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх, нэгэнт бий болсон сөрөг үр дагаврыг бага гэлтгүй тухай бүр нь нөхөн сэргээх замаар төслийг байгаль орчинд ээлтэйгээр хэрэгжүүлэх бололцоотой юм.

БОМТ-г хэрэгжүүлснээр дараах зорилтууд хангагдана. Үүнд:

- Монгол улсын БОАЖЯ-наас тавьж буй байгаль орчныг нөхөн сэргээх болон сөрөг нөлөөллийг бууруулах талаар тавьж буй шаардлагыг аль болохоор хангасан байх;

<sup>1</sup> Ерөнхий үнэлгээний дүгнэлт Онцгойлон анхаарах зүйлс (10)

- Төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны шат дамжлага бүрт технологийн журам зааврыг байгаль хамгаалах хууль тогтоомжийн холбогдох зүйл заалт, стандарт шаардлагад нийцүүлэх;
- Байгаль орчны менежментийн талаар БОНБНҮ-ээр дэвшүүлсэн зорилго зорилтыг хэрэгжүүлэх зөвлөмжийг биелүүлэх;
- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх болон байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний талаар төслийн холбогдох ажилтнуудад зориулан товч, тодорхой зааварчилгаа өгөх;
- Байгаль орчны менежментийн арга хэмжээ, үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан ажиллагсдын үүрэг хариуцлагыг тогтоосон, удирдлагын шатлалын дараалал бий болгох;
- Төсөл хэрэгжүүлэгч буюу гэрээт гүйцэтгэгч бүр байгаль орчныг хамгаалахтай холбоотой үүрэг хариуцлага мэдсэн байх ба үүргээ биелүүлэхэд шаардлагатай ур чадвар, бэлтгэл сургалт, мэргэжилтэй байх;
- Байгаль орчинд гарч болзошгүй сөрөг нөлөөлөл, эрсдлийг аль болохоор бууруулж, байгаль орчныг хамгаалж байгаль орчны тухайн төлөв байдлыг хэвийн хадгалах зорилтыг хангах үүднээс үүнд хамаарах тодорхой тогтолцоо, дэг журам, ажлын зааварчилгааг тодорхойлох;
- Тухайн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг төлөвлөж явуулахад лавлах баримт бичиг болох;

Төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг менежментийн төлөвлөгөөний зорилтуудтай нийцүүлэн явуулахын тулд байгаль орчны параметрууд тус бүрд сөрөг нөлөөллийг бууруулахаар төлөвлөгөөт ажил, төслийн ойр орчмын байгалийг хамгаалах талаар гүйцэтгэх ажлуудыг уг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан болно.

Иймд менежментийн төлөвлөгөө нь энэ төслийн салшгүй нэг хэсэг төдийгүй түүнийг хэрэгжүүлэх явцад байгаль орчныг хамгаалах талаар баримтлах бодлогын үндсэн чиглэл нь болж өгнө.

### ***Төслийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө***

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31 дүгээр зүйл болон 2012 онд шинэчлэн батлагдсан Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд (Төрийн мэдээлэл, 2012 оны 22 дугаар) аливаа төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрдэл хэсэг болох байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар заасан байна. Иймд дээрх хуулийн шаардлагын дагуу, төслийн үйл ажиллагаанаас тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардлыг хамт тодорхойлж, баримтлах хууль, дүрэм журам, стандартуудыг хамтатган байгаль хамгаалах төлөвлөгөөг боловсруулсан.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг төслийн хүчин чадлыг өргөтгөх, өөрчлөх бүрд нэмэлт хийж байх шаардлагатай. Мөн үүнээс гадна, БОМТ-ний хэрэгжилтийн тайланг заасан хугацаанд гаргаж төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн захиргаа, ойр орчмын нутаг дэвсгэр дэх иргэдэд танилцуулах тэдний саналыг нэгтгэн тусгах ажлыг

зохион байгуулах, оролцогч болон сонирхогч талуудад мэдээллийг ил тод байлгах арга хэмжээг авсан байх шаардлагатай.

#### 4.3 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр


Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31 дүгээр зүйл, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд зааснаар “Самартай-1” хайлуур жоншны ордыг ашиглах төслийг хэрэгжүүлэхдээ тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэг төсөл хэрэгжүүлэгч “Хөх жонш” ХХК-д зүй ёсоор тавигдаж байна. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэх бөгөөд орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгахаар хуульчлагдсан байна.

Хуулийн дээрх заалтыг удирдлага болгон “Самартай-1” хайлуур жоншны ордыг ашиглах төслийг хэрэгжүүлэх явцад “Хөх жонш” ХХК-аас байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан болон байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний үр дүн, төслийг хэрэгжүүлж буй Дорноговь аймгийн Айраг сумын нутаг дэвсгэрт бий болсон болон болзошгүй өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор хяналтын үзүүлэлтүүд, байршил, хийх хугацаа, зардал, баримтлах стандарт, аргачлалыг тодорхойлж энэхүү орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг (ОХШХ) боловсруулав.

Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр Хайлуур жоншны ордын талбайн төслийн болон нөлөөлөлд өртөж болзошгүй бүс нутагт гарах болзошгүй өөрчлөлтүүдийг эрт тодорхойлох, сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааны үр дүнг илтгэх, авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулах, орон нутгийн захиргаа, хяналтын байгууллага, нутгийн оршин суугчдад байгаль орчин, амьдрах орчны өөрчлөлтийн талаар бодит мэдээлэл өгөх үндсэн зорилготой.

ОХШХ-ийг хэрэгжүүлэхэд ашиглалтын 5 жилийн байдлаар (2022-2026 онуудад) **20035.2 мян.төг** шаардагдах бөгөөд эдгээрээс тухайн онд хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлон жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгаж, холбогдох зардлыг нарийвчлан тодотгох шаардлагатай.

ОХШХ-ийн хэрэгжилтийн тайланг заасан хугацаанд гаргаж төсөл хэрэгжиж буй Айраг сумын нөлөөллийн бүс түүний орчмын нутаг дэвсгэр дэх иргэдэд танилцуулах, сонирхогч талуудад мэдээллийг ил тод байлгах арга хэмжээг авсан байх шаардлагатай. Хагас жил бүр орчны хяналт, шинжилгээний үзүүлэлтийг анхааралтай судалж өөрчлөлтийн үндсэн шалтгааныг тодорхойлон цаашид байгаль хамгаалах төлөвлөгөөг улам боловсронгуй болгох, байгаль орчин болон тухайн нутагт амьдардаг иргэдийг аливаа сөрөг нөлөөллөөс хамгаалах арга хэмжээг илүү үндэслэлтэй, тодорхой болгоход ашиглах шаардлагатай.



Төслийн талбайн мониторингийн цэг

**Мониторингийн цэгийн байршил**

Д/д	Мониторингийн цэгийн байршил	Координат	
		Уртраг	Өргөрөг
<b>Хөрс</b>			
1	Уурхайн хотхон	109°20′42.44//	45°22′4.61//
2	Шимт хөрсний овоолго	109°20′32.11//	45°21′51.53//
3	Хөрсний овоолго	109°20′32.50//	45°21′55.59//
4	Нөлөөлөлд өртөөгүй талбай	109°20′29.02//	45°21′50.25//
<b>Ургамал</b>			
1	Уурхайн хотхон	109°20′41.69//	45°22′5.18//
2	Шимт хөрсний овоолго	109°20′33.45//	45°21′51.26//
3	Хөрсний овоолго	109°20′31.36//	45°21′55.15//
4	Нөлөөлөлд өртөөгүй талбай	109°20′28.54//	45°21′50.83//
<b>Агаар</b>			
1	Уурхайн хотхон	109°20′41.55//	45°22′3.59//
2	Уурхайн ам	109°20′34.23//	45°21′54.51//

## 2017 онд хийгдсэн шинжилгээ:

### Хөрс:

2017 онд хийгдсэн хөрсний зүсэлт, шинжилгээний дүнгээр хөрс нь саармаг ба сул шүлтлэг урвалын орчинтой, хөрнсий өнгөн үедээ карбонатгүй, ялзмагийн агууламж бага, цахилгаан дамжуулах чанар бага буюу давсжилтгүй хөдөлгөөнт фосфорын хангамж бага, хөдөлгөөнт калийн хангамж бага, механик бүрэлдэхүүн элсэнцэр. Хөрсний үржил шимийн ерөнхий түвшин бага байна.

2021 онд хийгдсэн хөрсний шинжилгээний дүнгээр хөрс нь сул шүлтлэг урвалын орчинтой, карбонатгүй, ялзмагийн агууламжаар бага зэрэг, цахилгаан дамжуулах чанар бага буюу давсжилтгүй, хөдөлгөөнт фосфор болон калийн хангамжаар бага, механик бүрэлдэхүүн элсэнцэр. Хөрсний үржил шимийн ерөнхий түвшин бага байна.

2017, 2021 оны хөрсний шинжилгээний дүнгээр төслийн талбайн хөрсний химийн үндсэн шинжид өөрчлөлт гараагүй бөгөөд хөрсний үржил шимийн ерөнхий түвшин бага байна.

### Ус:

2017 онд хийгдсэн худгийн усны шинжилгээний дүнгээр химийн бүрэлдэхүүнээрээ сульфат, гидрокарбонатын ангийн, натрийн бүлгийн, 1-р төрлийн, чанарын хувьд давсархаг, хатуувтар ус байна.

2021 онд хийгдсэн худгийн усны шинжилгээний дүнгээр химийн бүрэлдэхүүнээрээ хлор-сульфатын ангийн, натрийн бүлгийн, 1-р төрлийн, чанарын хувьд давсархаг, хатуулаг дотроо магнийн ион зонхилсон, хатуувтар ус байна.

Иймээс төсөл хэрэгжүүлэгч нь хүний унданд хэрэглэх тохиолдолд цэнгэгжүүлж, зөөлрүүлж хэрэглэх шаардлагатай.



### **5.0 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ**

“ХӨХ ЖОНШ” ХХК-ийн “Самартай-1” хайлуур жоншны ордыг далд уурхайн аргаар ашиглах төслөөс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах, байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийн үр дагаврыг бууруулах, урьдчилан сэргийлэх үүднээс уурхайн үйл ажиллагаатай уялдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөлөө.

Тухайн төлөвлөгөөг БОАЖЯСайдын 2019 оны 10 сарын 29-ны өдрийн А/618 дугаар тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах хянан батлах, тайлагнах журам”-ийн болон БОННУ-ний нэмэлт тодотголын тайлан, тухайн жилийн батлагдсан уулын ажлын төлөвлөгөө зэргийг үндэс болгон боловсруулсан.



**5.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө**

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж ийн зардал мян.төг	Зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
<b>Агаар</b>									
1	Төсөлд ашиглагдах машин механизмаас ялгаран гарах хорт хий орчны агаарыг бохирдуулах	Уурхайн бүх машин механизмд үзлэг оношлогоо хийлгэх	Уурхайн бүх автомашин	ш	4	-	300.0	Уурхайн ажил эхлэхээс өмнө	Агаарын тухай хууль 9, 11, 23-р зүйл MNS 585:2007 MNS 5919:2008
	Уул уурхайд ашиглагдаж буй замаас тоос дэгдэж хүрээлэн буй орчинд тархах	Ажилдчдыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол оруулах, хордлого тайлах хүнс, эмээр хангаж байх	Уурхайн хэмжээнд	ш	2	-	Үйл ажиллагааны зардлаар	2023	Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS5885:2008 MNS ISO4227-2002, “Хүрээлэн буй орчны агаарын чанарын хяналтын төлөвлөгөө” MNS4585-2007, “Агаарын чанар. Техникийн ерөнхий -
		Уурхайн дотоод тээвэрлэлтийн замыг услах	Зам	м <sup>2</sup>	-	-	Үйл ажиллагааны зардлаар	2023	
Усан орчинд үзүүлэх нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ									
2	Ус шавхан зайлуулалтын улмаас газрын доорх усанд хомстол үүсэх	Ус шавхан шугам бүрийг тоолууржуулах	Шүүрлийн худаг болон насосны шугам	ш	1	00.0	200.0	2023 оны 2-р улиралд	Усны тухай хууль MNS 4943 2011

			хоолой худаг						
		Тухайн жил уурхайгаас шавхан зайлуулсан усны төлбөрийг гэрээ болон ус ашиглах дүгнэлтэд заасны дагуу төлөх	Төслийн хүрээнд	-	-	-	Үйл ажиллагааны зардлаар	2023 оны 2-р улиралд	
		Ус ашиглах дүгнэлтийг орон нутгаар гаргуулах	Төслийн хүрээнд	-	-		Үйл ажиллагааны зардлаар	2023 оны 2-р улиралд	
		Ус ашиглах гэрээг байгуулах	Төслийн хүрээнд	-	-	-	Үйл ажиллагааны зардлаар	2023 оны 2-р улиралд	
Ургамал ба амьтны аймгийг үзүүлэх нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ									
3	Чимээ шуугиан, гэрлийн нөлөөгөөр ан амьтан үргэх, дайжих	Уурхайд галт зэвсэг байлгахыг хориглох, ажилчдад сургалт зохион байгуулах	Төсөл хэрэгжиж буй газар нутгийн хүрээнд				Үйл ажиллагааны зардлаар	2023 он	БУТХууль, MNS 6191:2010 MNS 5915:2008
Хөрсөн бүрхэвч, гадаргын хэлбэр төрхөнд үзүүлэх нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ									
4	Техникийн засвар үйлчилгээг зориулалтын талбайд хийгээгүйгээс шатах, тослох материал, нефтийн	Асгаралт болсон үед хэрэглэх шингээгч бодис, материалыг зохих газарт байршуулах	Ажиллах нийт хугацаанд - Тухай бүрт				200.0		MNS 5916:2008
		Ажилчдад асгаралтын үед авах арга	Ажиллах нийт хугацаанд				200.0	2023 оны 4-5 саруудад	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх

бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж бохирдуулах, усаар угаагдаж бохирдох	хэмжээний талаар сургалт явуулах	- Тухай бүрт						тухай хууль MNS 5916:2008
	“Тэр бум” мод тарих үндэсний хөдөлгөнөөд 500 ширхэг мод, үрсэлгээ суулгах	Үндэсний хөдөлгөөн аян	ш	-	-	300.0	2023 онд шимт хөрсний овоолго хийх бүрт	
	Шатах тослох материалаар бохирдсон хөрсийг цэвэрлэж саармагжуулах арга хэмжээг авах	Төслийн талбай	-	-	-	300.0		
Бүгд						<b>1500.0</b>		

## 5.2 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Манай компани нь 2019-2022 онд үйл ажиллагаа явуулаагүй тул 2023 онд нөхөн сэргээлт хийх талбай байхгүй болно.

## 5.3 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгааллын арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал	Зардал мян.төг	Баримтлах стандарт, аргачлал
Биологийн олон янз байдлын менежментийн арга хэмжээг тодорхойлох	Эвдэрсэн газрын нөхөн сэргээн	Орон нутгийн Байгаль орчны улсын байцаагчийн зааж өгсөн газарт	-	-	1000.0	БОННҮ-ний аргачлал, Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх гарын авлага
Нийт					<b>1000.0</b>	

## 5.4 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Энэ онд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний ажил төлөвлөгдөхгүй болно.

## 5.5 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Ашиглалтын талбайн хэмжээнд түүх, соёлын дурсгалт зүйл илрээгүй гэсэн хэдий ч Археологи болоод Палеонтологийн нарийвчилсан судалгааг хийлгэхээр төлөвлөж байна. Хэрэв нарийвчилсан судалгаагаар түүх соёлын дурсгалт зүйл болоод олдвор олдвол холбогдох байгууллагад мэдэгдэн шаардлагатай арга хэмжээг авна.

**5.6 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө**

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргээх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний, цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
<b>Хөдөлмөр хамгаалалал</b>								
1.1	Төслөөс гэнэтийн аваар осол хөдөлмөр хамгааллын зөрчил илрэх	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангах	Нийт ажилчид	-	-	ҮАЗ	2023	
1.2		Ажил эхлэхээс өмнө хөдөлмөр хамгааллын заавар зөвлөгөөг өдөр бүр өгч байх	Нийт ажилчид			ҮАЗ	2023 он	
<b>Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх</b>								
2.1	Төслийн үйл ажиллагаанд техникийн зориулалттай шатах, тослох материалын аюулгүй ажиллагааг хангаагүйгээс галын аюул гарах Аянга цахилгаан, хэт халалт, хээрийн түймэр, гэнэтийн хүчтэй цахилгаан гүйдлийн нөлөөгөөр галын аюул гарах	Гал унтраах хэрэгсэл түүний бүрэн бүтэн байдалд хяналт тавьж ажиллах.	Уурхайн тосгон Тэсрэх материалын агуулах ШТС	2		ҮАЗ	6 сар	MNS5078-2001, MNS 5390:2004,
<b>Байгалийн аюул гамшиг</b>								

3.1	Байгалийн гамшиг, аюул ослоос үүсэх эрсдэлүүд	Байгалийн аюул гамшиг, аваар осол, гал түймрийн үед авах арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах				ҮАЗ	6 сар	Гамшгаас хамгаалах тухай хууль,
<b>Тэсрэх материалын агуулах</b>								
4.1	Тэсэлгээний ажил болон тэсрэх материалын агуулахтай холбоотой сөрөг нөлөөлөл	Уурхайн тэсэлгээний ажлыг явуулахдаа тэсрэх материалтай харьцах, тэсрэх бодис тээвэрлэх, хадгалах, хураах, устгах ажиллагаанд мөрдөж ажиллах	Тэсрэх материалын агуулах болон тэсэлгээ хийх бүрт	-	-	ҮАЗ	2023 он	“Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”,
4.2		Тэсэлгээний ажлыг мэргэжлийн үнэмлэх бүхий урд нь тэсэлгээ хийж байсан туршлагатай хүмүүсээр хийгэх	Тэсэлгээний ажил хийх бүрт	-	-	ҮАЗ	2023 он	
	Нийт					-		

### 5.7 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Эхний 1 жилийн зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ахуйн	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31.3-д заасны дагуу Хог хаягдлын тоо хэмжээг бүртгэж мэдээ тайланг суманд гаргаж өгөх	уурхай, Ажилчдын тосгон	ш	1	-	-	10-р сар	Хог хаягдлын тухай хууль, 9-р зүйл БОНХСайдын 2014 оны 04 дүгээр сарын 09-

		Хог хаягдлыг ангилан дахин боловсруулах үйлдвэрт тушаах	Төслийн хүрээнд	-	-	-	300.0	10 -р сар	ний өдрийн А-116 дугаар тушаалын хавсралт Хог хаягдлын тухай хуулийн 14-р зүйл Хог хаягдлын тухай хуулийн 11-р зүйл Хог хаягдлын тухай хуулийн 16-р зүйл
		Хогийн цэг, бие засах газарт ариутгал халдваргүйжүүлэлтийг сар бүр хийж байх	Хогийн цэг, ОО	ш	4	50.0	200.0	Сар бүр	
		Төсөл хэрэгжих талбайгаас 50 метр зай дах хог хаягдал цэвэрлэх	Төслийн талбайн ойр орчим	ш	2	-	ҮАЗ	8-р сар	
		“Хог хаягдлын гэрээ” байгуулан, гэрээний дагуу хог хаягдлыг сумын төвлөрсөн цэгт зөөж зайлуулах, тээвэрлүүлэх	Төслийн хэмжээнд	-	-	-	Гэрээнд заасан төлбөрийн хэмжээгээр	5-р сар	
									MNS 5924 : 2015
2	Аюултай	Аюултай хог хаягдлын цэгт анхааруулах тэмдэг тэмдэглэгээ байршуулах	Төсөл хэрэгжих талбай	ш	2	-	ҮАЗ	7-р сар	Хог хаягдлын тухай хууль
		Аюултай хог хаягдлыг дахин боловсруулах эрх бүхий ААНБ-тай гэрээ хийн нийлүүлэх	Төслийн хүрээнд	ш	1	-		10-р сар	
		Аюулдтай хог хаягдлыг бүртгэлжүүлж мэдээллийг сумын байгаль орчны мэргэжилтэн хүргүүлэх	Төслийн хүрээнд	ш	1	-	-	10-р сар	
Нийт							<b>700.0</b>		

### 5.8 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн өртөг (мян.төг)	Зардал (мян.төг)	Баримтлах стандарт ба арга, аргачлал
<b>Хөрс</b>							
1	Орчны хөрсөн дэх эмгэг төрүүлэгч бактерийн тоо	Үйлдвэрийн салхины зонхилох чигийн доод хэсэгт нэг цэг сонгох	Жилд 2 удаа 2, 3-р улиралд	2	50.0	100.0	MNS 6341:2012 Хөрсний чанар. Хөрсөнд эрүүлзүйн нян судлалын шинжилгээ хийх арга
2	Орчны хөрсний хүнд металл	Үйлдвэрийн ойролцоо		2	50.0	100.0	MNS ISO 11047 : 2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчныхандмалд кадьми, хром, кобальт, зэс, хартугалга, мангани, никель, цайрыгтодорхойлох. Дөлний болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга
3	Хөрсний агро химийн үндсэн үзүүлэлтүүд	Төсөл хэрэгжих талбай		2	50.0	100.0	MNS3310-1991 Хөрсний агро химийн үзүүлэлтийг тодорхойлох
		Шимт хөрсний овоолго	2	50.0	100.0	MNS ISO 10390 : 2001 Хөрсний чанар. PH-ыг тодорхойлох MNS 2306 : 1986 Хөрсний ширхэгийн бүрэлдэхүүнийг тодорхойлох лабораторийн арга. Хээрийн туршилт.	
<b>Ус</b>							



2	Ундны усан дахь эмгэг төрүүлэгч бактерийн тоо	Гүний худаг	Жилд 2 удаа 2, 3-р улиралд	2	25.0	50.0	<p>MNS ISO 6222 : 1998</p> <p>Усны чанар – Амьдрах чадвартай бичил биетний тоог тоолох. Тэжээлт орчны дотор нь буюу гадарга дээр нь ургасан нянгийн бөөгнөрлийг тоолох</p> <p>MNS ISO 9308-2:1998</p> <p>Усны чанар – Гэдэсний бүлгийн бичил биетэн, халуунд тэсвэртэй гэдэсний бүлгийн бичил биетэн болон таамаглаж буй E.coli-г илрүүлэх ба тоолох. 1-р хэсэг: Ялтаст шүүлтүүрээр шүүх арга</p> <p>MNS 6461-1:1999</p> <p>Усны чанар – Сульфит задлах агааргүйтэнбичил биетний (clostrida) үр тоолох байлрүүлэх. 1-р хэсэг. Шингэн тэжээлт орчиндбаяжуулах арга.</p> <p>MNS 6546:2015</p> <p>Ундны усанд ялтаст шүүлтүүрийн аргаар Pseudomonas aeruginosa актерийг илрүүлэх</p>
3	Ундны усны бүрэн шинжилгээ	Гүний худаг		2	50.0	100.0	<p>MNS 0900 : 2018</p> <p>Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийгхамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ</p>
4	Ундны усан дахь хүнд металлын агууламж	Гүний худаг, бохирын цооног		2	50.0	100.0	<p>MNS ISO 8288 : 1999</p> <p>Усны чанар. Зэс, цайр, хар тугалга, кобальт, кадьми тодорхойлох. Атом шингээлтийн спектрометрийн арга</p>
5	Уурхайн гүнээс гарч байгаа шүүрүүлэлтийн усыг			2	25.0	50.0	

	шинжилгээнд хамруулах						
<b>Агаар</b>							
Тоосжилт (PM <sub>10</sub> , PSM, PM <sub>2.5</sub> ) Гадаад болон дотоод орчны дуу чимээ, доргио, чичиргээ Ажлын байрны эрүүл ахуйн үзүүлэлтүүд (тоос, дуу чимээ, гэрэлтүүлэг, чийгшил болон физик бохирдлын түвшин) Бохирдлын цэгэн эх үүсвэр (O <sub>2</sub> , SO <sub>2</sub> , NO <sub>2</sub> , CO)	Уурхайн карьер  Ажилчдын тосгон	Жилд 1 удаа 2, 3-р улиралд	2	50.0	100.0	“Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” MNS 4585:2016 “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хөдөлмөрийн эрүүл мэнд. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага” MNS4990:2015 «Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага” MNS5002:2000	
<b>Нийт</b>				-	<b>800.0</b>		

### 5.9 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилсан тооцсон төсөв мян.төг	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2023 он				
			Сар 1-4	Сар 5-8	Сар 9-12		
1	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, тайланг боловсруулж жил бүр батлуулж ажиллах	Дотоод зардаар				БО мэргэжилтэн	БОМТ-нд тусгасан арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.
2	Уурхайн ажилчдын тодорхой хувийг Айраг сумын иргэдээр бүрдүүлэх	Дотоод зардлаар	Тухай бүрт нь			Уурхайн дарга	БОНХЯ-ны сайдын 2014 оны 1-р сарын 06- ны өдрийн А-03 тоот журам
3	Газар, ус ашигласны болон бусад төлбөрийг төлөх	Дотоод зардлаар	Тухай бүрт нь			Уурхайн дарга	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль болон бусад

### 5.10 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад

#### тайлагнах хуваарь

БОМТ, БОМТ хэрэгжилтийг тайлагнах, оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны төв	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
Олон нийтэд танилцуулах	2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг нөлөөлөлд өртөгч оршин суугчидад танилцуулах	2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг нөлөөлөлд өртөгч оршин суугчидад танилцуулах	6 сар	ҮАЗ	Байгаль орчны мэргэжилтэн	Нөлөөлөлд өртөгч өрх
	Байгаль орчны чиглэлээр хийсэн ажлын танилцуулгыг олон нийтэд хэвлэл	БОМТ-ын биелэлт	10 сар	ҮАЗ	Байгаль орчны мэргэжилтэн	-

	мэдээллийн хэрэгсэл ашиглах тайлагнах					
Аймгийн байгаль орчны газар	БОМТ хэрэгжилтийн тайланг хүргүүлэх, тайлагнах	БОМТ-ийн тухайн жилийн тайлан, Ирэх оны төлөвлөгөө	10 сард	ҮАЗ	Байгаль орчны мэргэжилтэн	Төслийн талбай, уурхай
БОАЖЯ	Тайлан, төлөвлөгөөг цаасан хэлбэрээр болон Файл хэлбэрээр		11 сар	ҮАЗ	Байгаль орчны мэргэжилтэн	УБ хот
<b>Бусад</b>				<b>500.0</b>		

## 6.0 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ

№	Мэдээллийн төрөл	Нийт зардал сая.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	1.5
2	Нөхөн сэргээлтийн зардал	-
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төсөв	1.0
4	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний төсөв	ҮАЗ
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төсөв	0.7
6	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөв	ҮАЗ
7	Тухайн жилийн орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн нийт төсөв	0.8
8	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төсөв	0.5
<b>Тухайн жилийн байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний нийт төсөв</b>		<b>4.5</b>

**Хавсралт материалууд**